

**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ
ХАДГАЛАХ, БИРЖИЙН БУС АРИЛЖААГААР
ӨМЧЛӨХ ЭРХ БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1 Энэ журмын зорилго нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид хадгалагч гэх/-ийн төвлөрсөн хадгаламжид хөрөнгөөр баталгаажсан бонд /цаашид бонд гэх/-ыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх, уг эрхэнд үүрэг ногдуулсныг бүртгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү харилцаанд Монгол Улсын иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Төв банкны репо санхүүжилтийн тухай журам болон хадгалагч талын холбогдох үйл ажиллагааны журмуудыг удирдлага болгоно.

1.3 Бондын хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлтэй холбогдсон үйл ажиллагааг хадгалагчийн Хадгаламж өмчлөх эрх бүртгэл, кастодианы алба /цаашид ХӨЭБКА гэх/, мөнгөн хөрөнгийн гүйлгээг Санхүү нягтлан бодох бүртгэлийн алба /цаашид СНББА гэх/ тус тус хийж гүйцэтгэнэ.

1.4 Энэхүү журамд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулна.

Хоёр. Нэр томъёо

2.1 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 “бонд гаргагч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу тодорхой хуримтлал бий болгох зорилгоор бонд гаргасан этгээдийг;

2.1.2 “бонд эзэмшигч” гэж энэ журмын дагуу төвлөрсөн хадгаламжид хадгалуулсан бондыг анхдагч болон хоёрдогч зах зээл дээр худалдан авсан этгээдийг;

2.1.3 “анхдагч зах зээл” гэж бонд гаргагч өөрөө худалдахтай холбогдох харилцааг;

2.1.4 “хоёрдогч зах зээл” анхдагч зах зээлд худалдсан бондыг дахин худалдах, худалдан авахтай холбогдох харилцааг;

2.1.5 “Т+0” гэж төлбөр шилжиж ирсэн өдөр;

2.1.6 “Т+1” гэж төлбөр шилжиж ирсний дараагийн өдөр;

2.1.7 “Бондын төлбөр” гэж бондыг худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр шилжүүлэхэд төлөгдөх төлбөр;

2.1.8 “бондын үндсэн төлбөр” гэж графикийн дагуу бонд гаргагчаас бонд эзэмшигчид төлж буй төлбөр;

**Гурав. Бондыг төвлөрсөн хадгаламжид хадгалах болон
хасах үйл ажиллагаа**

3.1 Бондыг төвлөрсөн хадгаламжид хадгалахдаа бонд гаргагчийн /цаашид хадгалуулагч гэх/ хүсэлт, түүний эрх бүхий этгээдийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/-

ны тогтоолыг үндэслэнэ.

3.2 Хадгалагч нь хадгалуулж буй бондыг төрөл тус бүрээр тусгайлсан код өгч хадгаламжийн бүртгэл хийнэ.

3.3 Хадгалагч нь хадгалуулагчтай бондын хадгаламжийн гэрээ /гэрээ-1/ байгуулах ба гэрээг бичгээр үйлдэнэ.

3.4 Энэхүү гэрээнд дараах зүйлсийг заавал тусгасан байна. Үүнд:

- хадгаламжийн хэлбэр
- бондын нэр
- бондын хугацаа
- хадгалуулах бондын тоо ширхэг, нэгжийн үнэ, нийт үнийн дүн
- жилийн хүүгийн хувь
- үндсэн болон хүүгийн төлбөр хийх хугацаа, график
- хадгаламжийн үйлчилгээний хөлсний хэмжээ, төлөх хугацаа
- талуудын эрх, үүрэг, хариуцлага
- хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл

3.5 Бондын үндсэн төлбөр хийгдсэн тухай бүрт төлбөрийн хэмжээ, тооцоо нийлсэн актыг үндэслэн бондыг хасах бүртгэл хийгдэнэ.

Дөрөв. Бондын өмчлөх эрхийг бүртгэх

4.1 Бонд эзэмшигч бүр нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид журмын / гэрээ-2 /-ын дагуу данс нээлгэсэн байна.

4.2 Анхдагч зах зээлд биржийн бус арилжаагаар арилжигдсан бондын бүртгэлийг СЗХ-ноос ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн бонд эзэмшигч тус бүрийн дансанд бүртгэнэ.

4.3 Хоёрдогч зах зээлд биржийн бус арилжаагаар арилжигдсан бондын бүртгэлийг хийхдээ арилжаа хийсэн талуудын хооронд байгуулсан гэрээг үндэслэн бонд болон бондын төлбөрийн гүйлгээг нэгэн зэрэг хийнэ.

Тав. Бондоор хүлээх үүргийг бүртгэх

5.1 Дараах тохиолдолд бондоор хүлээх үүргийг хүлээнэ. Үүнд:

- 5.1.1 Буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээ
- 5.1.2 Төв банкны репо хэлцэл
- 5.1.3 Банк хоорондын буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл
- 5.1.4 Барьцаа, батлан даалтын гэрээ

5.2 Бонд эзэмшигч нь энэ журмын 5.1.1-д заасны дагуу гэрээг бүртгүүлэх тохиолдолд эзэмшиж буй бондыг худалдан авагчийн дансанд шилжүүлнэ. Энэ гүйлгээг гэрээг хүлээн авч, журмын 7.3-т заасан үйлчилгээний хөлс төлөгдсөн тохиолдолд Т+0 хугацаанд хийж гүйцэтгэнэ.

5.3 Талууд гэрээндээ өөрөөр тохиролцоогүй бол буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээний хугацаанд худалдан авагч нь гуравдагч этгээдтэй тухайн бондоор дахин буцаан

худалдан авах нөхцөлтэйгээр худалдах, барьцаалж болох ба энэ нь анхны гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй. Энэ тухай талууд гэрээ хийх тухай бүрт тодорхой тусгана. Харин буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээний хугацаанд худалдан авагч тал бондоор гэрчлэгдсэн өмчлөх эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

5.4 Энэ журмын 5.1.1-д заасан гэрээг Монгол банкны “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ” болон “Төв банкны репо санхүүжилтийн журам”-тай нийцсэн байдлаар тогтоох бөгөөд дараах зүйлийг заавал тусгасан байна. Үүнд:

- 5.4.1 бондын нэр
- 5.4.2 тоо ширхэг
- 5.4.3 жилийн хүүний хувь
- 5.4.4 эзэмших хугацаа
- 5.4.5 санхүүжилт олгогчийн худалдан авах өдөр, худалдан авах үнэ
- 5.4.6 бонд эзэмшигчийн буцаан худалдаж авах өдөр, үнэ
- 5.4.7 буцаан худалдан авалт хийгдээгүй тохиолдолд авах арга хэмжээ
- 5.4.8 гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх /энэ хэсэг зөвхөн 5.1.1-д зааснаас бусад гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх/

5.5 Энэ журмын 5.1.1-д заасан нөхцөлд хийгдэх бүртгэл нь бондын төлбөр болон бондын шилжүүлэг нэгэн зэрэг хийгдэнэ.

5.6 Энэ журмын 5.1-д заасан гэрээний хугацаанд төлөгдөх хүүний орлогыг өөрийн эзэмшлийн бондыг буцаан худалдан авах нөхцөлтэй худалдсан этгээд авах эрхтэй.

5.7 Доорхи хийгдсэн хэлцлийг Монгол банкны цахим арилжааны системээр ирүүлсэн мэдээллийг үндэслэн өмчлөх эрхийг шилжүүлэн баталгаажуулна. Үүнд:

- 5.7.1 Төв банкны репо хэлцэл
- 5.7.2 Банк хоорондын буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл
- 5.7.3 Репо санхүүжилтийн арилжаа
- 5.7.4 Репо оварнайг санхүүжилтийн арилжаа

5.8 Энэ журмын 5.1.1-д заасан гэрээгээр бондын буцаан худалдан авах өдөр бондын үндсэн төлбөр дуусахаас ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө байна.

5.9 Энэ журмын 5.1.2-г заасан гэрээний бүртгэлийг хадгалагчийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам”-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Бондын төлбөр тооцоо

6.1 Хадгалагч нь хоёрдогч зах зээлд биржийн бус арилжаагаар арилжигдах бондын төлбөр тооцоо, бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн тооцоо, мөн буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээний дагуу худалдан авах болон буцаан худалдан авах төлбөрийг зөвхөн хадгалагчийн тоот дансаар дамжуулан хийж гүйцэтгэнэ.

6.2 Төлбөр шилжүүлэгч тал нь журмын 6.1-д заасан төлбөрүүдийг ажлын өдрийн 12.00 цагаас өмнө хадгалагчийн дансанд шилжүүлсэн бол T+0 хугацаанд, 12.00 цагаас хойш хийсэн бол T+1 хугацаанд багтаан холбогдох төлбөр тооцоог хийж дуусгана. Өөрөөр хэлбэл хадгалагч тал 12.00 цагаас өмнө төлбөрийг хүлээн авсан тохиолдолд тухайн өдрийн 14.00-16.30 цагийн хооронд төлбөрийг хүлээн авагчид шилжүүлнэ. Хэрэв 12.00 цагаас хойш

төлбөр хүлээн авсан тохиолдолд дараагийн ажлын өдрийн 09.00-12.00 цагт багтаан төлбөрийг шилжүүлнэ.

6.3 Төлбөр болон түүнтэй холбоотой үйлчилгээний хөлс, шимтгэлийн хэмжээ бүрэн гүйцэд төлөгдөөгүй тохиолдолд хадгалагч тал төлбөр тооцоог хийж гүйцэтгэхгүй ба үүнтэй холбоотой үүссэн хохирлыг төлбөр шилжүүлэгч тал бүрэн хариуцна.

Долоо. Үйлчилгээний хөлс

7.1 Бонд гаргагч нь хадгалагчийн “Үнэт цаасны хадгаламжийн журам”-ын 5.2-т заасны дагуу хадгаламжийн үйлчилгээний хөлс төлнө.

7.2 Журмын 4.2-т заасан өмчлөх эрхийн бүртгэл хийгдэх тухай бүрд бонд эзэмшигч тус бүрээс 4.3- т заасан өмчлөх эрхийн бүртгэл хийгдэх тухай бүрд худалдан авагч талаас үнийн дүнгийн 0.005%-тай тэнцэх хэмжээний шимтгэл тооцно.

7.3 Журмын 5.1.1-д заасан Буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээгээр өмчлөх эрхийн бүртгэл хийгдэхэд Репо гэрээг үндэслэн хэлцэл тухай бүрт бонд зарагч талаас үнийн дүнгийн 0.01%-тай тэнцэх хэмжээний шимтгэл тооцно.

7.4 Бондоор хүлээх үүргийн гүйцэтгэл бүртгэх тохиолдолд бондын үнийн дүнгээс “ҮЦТХТ” ХХК-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагааны журмын дагуу шимтгэл тооцно.

Найм. Мэдээлэл, судалгаа

8.1 Алба нь бондын хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн талаарх сарын мэдээ, тайланг дараа сарын 5-ны дотор гаргаж бонд гаргагч болон холбогдох эрх бүхий байгууллагад /СЗХ, Монголбанк, Сангийн яам гэх мэт/ тус тус хүргүүлнэ.

8.2 Мэдээлэл, судалгаа нь албаны захирлаар хянагдаж баталгаажна.

Ес. Хариуцлага

9.1 Хадгалагч талын ажилтан хадгалагдаж буй бондын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан, компьютер дээрх файлыг санаатай болон болгоомжгүй үйлдлээр гэмтээсэн, устгасан, хадгаламжийн бүртгэлтэй холбоотой мэдээ судалгааг хувийн ашиг сонирхолд нийцүүлж боловсруулсан, бусдад тараасан, буруу болон хуурамч тодорхойлолт гаргах, хувь хүн болон байгууллагын нууцыг задруулбал хариуцлагыг хадгалагч тал бүрэн хүлээнэ.

9.2 Хадгалуулагч тал бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаандаа шилжүүлээгүйгээс бонд эзэмшигчид хохирол учирсан тохиолдолд 2 талын харилцан зөвшөөрсөн гэрээгээр зохицуулна.

Улаанбаатар хот
2016 он

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БОНДЫН ХАДГАЛАМЖИЙН БОЛОН ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

200.. оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ҮЦТХТ” ХХК /цаашид хадгалагч гэх/, нөгөө талаас
..... /цаашид хадгалуулагч гэх/ бид /цаашид талууд гэх/ Монгол
Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Хөрөнгөөр баталгаажсан
бондыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх тухай журам”-ыг тус
тус үндэслэн харилцан тохиролцож, дор дурьдсан нөхцөлтэйгээр байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1 Гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтийн дагуу гаргасан
бондыг хадгалах, хадгалуулагч хадгалагч талд хадгаламжийн үйлчилгээний хөлс
төлөх, хадгаламжийн хугацаа, хадгаламжаас чөлөөлөх, хадгалуулсан үнэт цаастай
холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад
оршино.

Хоёр. Хадгалуулах бондны нэр, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлс

2.1 Хадгалуулагч нь хадгалагч талын хадгаламжид нэртэй ...
... .. төгрөгний үнэ бүхий, жилийн хувийн хүүтэй ширхэг
бондыг хадгалуулахдаа хугацаанаас үл хамааран нийт гаргасан бондын үнийн дүнгээс
.....%-тай тэнцэх хэмжээний үйлчилгээний хөлсийг нэг удаа төлнө.

Гурав. Бонд хадгалах хугацаа

3.1 Хадгаламжийн хугацаа нь гэрээ байгуулж үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжид
бүртгэсэн өдрөөс эхлэн тоологдож бондын сүүлийн үндсэн болон хүүгийн төлбөр
төлөгдөж дуусах хүртэл хугацаанд хүчинтэй.

Дөрөв. Бондын төлбөрийг зуучлан гүйцэтгэх

4.1 Бонд гаргагч болон бонд эзэмшигч хоёрын хооронд хийгдэх бонд, бондын
үндсэн болон хүүгийн төлбөрийг хадгалагч тал “Хөрөнгөөр баталгаажсан бондыг
хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх тухай журам”-ын 6-р зүйлд
заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Тав. Хадгалуулагчийн эрх, үүрэг

5.1 Хадгалуулагч дараах эрх, үүрэгтэй :

- 5.1.1 хадгалагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;
- 5.1.2 бонд эзэмшигчдийн бүртгэлийг үнэ төлбөргүй гаргуулах;

- 5.1.3 гаргасан бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн төлөлтийн судалгаа, бусад холбогдох мэдээлэл, судалгаа гаргуулах
- 5.1.4 гаргасан бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг цаг хугацаандаа шилжүүлэх;
- 5.1.5 хадгаламжийн үйлчилгээний хөлсийг төлөх;

Зургаа. Хадгалагчийн эрх, үүрэг

6.1 Хадгалагч дараах эрх үүрэгтэй :

- 6.1.1 хадгалагдаж буй бондын бүрэн бүтэн байдлыг хангах;
- 6.1.2 бондын төлбөрийг зуучлан гүйцэтгэх;
- 6.1.3 бонд эзэмшигчдийн бүртгэлийг үнэн зөв хөтлөх;
- 6.1.4 холбогдох журамд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хадгалуулагчид мэдэгдэх;
- 6.1.5 хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөгдөөгүй тохиолдолд бонд бүртгэх болон төлбөр тооцоо гүйцэтгэхээс татгалзах;

Долоо. Талуудын хариуцлага

7.1 Хадгалагч хадгалуулагчийн хадгалуулсан бондын бүрэн бүтэн байдлыг гэрээний хугацаанд хангаагүйгээс учирсан хохирлыг бүрэн хариуцна.

7.2 Хадгалагч бонд эзэмшигчдийн бүртгэлийн үнэн зөвийг хариуцна.

7.3 Хадгалуулагч бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаандаа шилжүүлээгүйгээс бонд эзэмшигчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж барагдулна.

7.4 Энэ гэрээний 6.1.5-д зааснаар хадгалагч тал татгалзаж бондыг бүртгээгүйгээс бусдад учирсан хохирлыг хадгалуулагч тал хариуцна.

Найм. Гэрээ цуцлах үндэслэл

8.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ аль нэг тал биелүүлээгүй дараах тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө цуцлуулахаар нөгөө тал хүсэлт гарган өөрт учирсан хохирлоо нэхэмжлэнэ.

- 8.1.1 хадгалуулсан бондны бүрэн бүтэн байдлыг хангаагүй;
- 8.1.2 бондын төлбөрийг зуучлан гүйцэтгээгүй;
- 8.1.3 бонд эзэмшигчдийн бүртгэл хөтлөөгүй;
- 8.1.4 бонд эзэмшигчдийн бүртгэлийг буруу гаргасан;
- 8.1.5 хадгалуулагч бонд хадгалуулах талаар хүсэлтдээ хуурамч мэдээ, материал хавсаргасан нь тогтоогдсон;
- 8.1.6 хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөхөөс татгалзсан;

Ес. Бусад

9.1 Гэрээнд талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

9.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд зөвшилцөлд хүрэх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд үл хүрвэл шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

9.3 Гэрээнд талууд харилцан тохиролцож нэмэлт өөрлөлт оруулж болох бөгөөд энэхүү гэрээний адил бичгээр үйлдэж, гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно. Тухайн нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Хадгалагч тал:

.....

/...../

Гүйцэтгэх захирал

.....

/...../

ХӨЭБКА-ны захирал

Утас: 7011-3671

Факс: 7011-4424

Хаяг: Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 16/1

Хадгалуулагч тал:

.....

/...../

Гүйцэтгэх захирал

.....

/...../

.....

Утас:

Факс:

Хаяг:

.....

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ДАНС НЭЭЛГЭХ ГЭРЭЭ

Нэг талаас “Үнэт цаасны, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид ҮЦГХТ гэх/ нөгөө талаасбанк /цаашид харилцагч гэх/ бид харилцан тохиролцож, дор дурьдсан нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1 Энэхүү гэрээгээр харилцагч “.....” бондыг худалдан авахтай холбогдуулан төвлөрсөн хадгаламжид данс нээх, тухайн дансаар хийгдэх гүйлгээнд оролцох талуудын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2 Энэ гэрээний дагуу нээгдэх данс нь зөвхөн Засгийн газрын өрийн бичгийг биржийн бус арилжаагаар худалдах, өмчлөх эрх бүртгэх, түүний төлбөр тооцоог гүйцэтгэхэд ашиглагдах болно.

Хоёр. Данс нээх, бүрдүүлэх материал

2.1 Төвлөрсөн хадгаламжид нээх харилцагчийн дансыг ҮЦГХТ-д энэ гэрээний дагуу шууд нээх бөгөөд дор дурьдсан материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 2.1.1 данс нээх тухай хүсэлт;
- 2.1.2 аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 2.1.3 төвлөрсөн хадгаламжийн дансаар орлого зарлагын гүйлгээ хийхэд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтныг томилсон шийдвэр, түүний нотариатаар гэрчлүүлсэн гарын үсгийн маягт;

2.2 Гэрээний дагуу төвлөрсөн хадгаламжид нээгдэх данс нь брокер дилерийн компаниар дамжихгүй бөгөөд банк өөрийн дансны хуулгыг ҮЦГХТ-өөс шууд авна.

Гурав. Харилцагчийн эрх, үүрэг

3.1 Харилцагч дор дурьдсан эрх үүрэгтэй. Үүнд:

3.1.1 төвлөрсөн хадгаламжид данс нээлгэхдээ шаардлагатай мэдээллийг үнэн зөв, гаргацтай, алдаагүй бичих;

3.1.2 төвлөрсөн хадгаламжийн данс нээлгэх үйлчилгээний хөлсийг саадгүй төлөх;

3.1.3 баталгаажсан баримтаар гүйлгээ хийлгүүлэх;

3.1.4 төвлөрсөн хадгаламжийн дансны ерөнхий мэдээлэл /аж ахуйн нэгжийн регистрийн дугаар, хаяг, эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн гэх мэт/-д өөрчлөлт орсон тухай бүр ҮЦГХТ-д мэдэгдэж зохих өөрчлөлтийг оруулах;

3.1.5 худалдах худалдан авах гэрээ болон буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээний үндсэн дээр бонд шилжүүлэх, шилжүүлэн авах тохиолдолд гүйлгээний баримтыг гүйлгээ хийгдэх өдрийн 12.00 цагаас өмнө ҮЦГХТ-д ирүүлсэн байх;

3.1.6 өөрийн дансны гүйлгээний талаарх мэдээллийг лавлаж, дансны хуулга гаргуулан авах;

Дөрөв. ҮЦТХТ-ийн эрх үүрэг

4.1 ҮЦТХТ дор дурьдсан эрх үүрэгтэй. Үүнд:

4.1.1 харилцагчийн дансанд хийгдэх гүйлгээний нууцыг хадгалж, гүйлгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийх;

4.1.2 төвлөрсөн хадгаламжийн дансанд гүйлгээ хийгдсэний дараа харилцагчийн хүсэлтээр дансны хуулгыг гаргаж өгөх;

4.1.3 энэ гэрээний 3.1.5-д заасан хугацаанд ирүүлсэн баримтыг үндэслэн гүйлгээг Т+0 хугацаанд, 12.00 цагаас хойш хийсэн бол Т+1 хугацаанд багтаан тус тус холбогдох төлбөр тооцоог хийж дуусгах;

Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1 ҮЦТХТ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас харилцагчийн мөнгөн хөрөнгө болон бондны гүйлгээ саатсан, хугацаа хожимдуулснаас харилцагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

5.2 Үүргийн гүйцэтгэл хангуулах болон буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс бусдад учирсан хохирлыг уг гэрээгээр үүрэг хүлээсэн тал хариуцна.

Зургаа. Бусад

6.1 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү гэрээний адил бичгээр үйлдэж, гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

6.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд зөвшилцөлд хүрэх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд үл хүрвэл шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан

ҮЦТХТ ХХК:

..... банк:

Гүйцэтгэх захирал

.....
/ /

.....
/ /

.....

.....

/ /
ХӨЭБКА-ны ахлах ажилтан

/ /